



Бидний зорилго

Монгол-Од сургууль нь 2011 онд байгуулагдсан. Бидний зорилго нь өөрийн эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарласан дэлхийн иргэн бэлтгэхын тулд Монгол-Америкийн сургалтын хөтөлбөрт хийсэн харьцуулалтын дагуу чанартай боловсрол олгоход оршдог билээ.

Хүндэт эцэг эх, асран хамгаалагчдад,

Монгол Од сургуульд тавтай морилно уу! Таны хүүхдийн бидэнтэй хийх эрдмийн аялал таалагдана гэж найдаж байна. Сургуулийн үйл ажиллагаа, сургалттай холбоотой нийтлэг асуултанд хариулах зорилгоор энэхүү гарын авлагыг бэлтгэлээ. Та уг гарын авлагыг лавлагаа болгон ашиглахаас гадна санал хүсэлт, асуулт байвал хүүхдийнхээ багштай холбогдож болно. Эцэг эхтэйгээ хамтран ажиллах нь бидний хувьд маш чухал бөгөөд таны хүүхдийг амжилттай суралцахад үнэтэй хувь нэмэр болдог. Та манай сургуульд хүүхдээ амжилттай, үр өгөөжтэй суралцуулж хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,

Монгол Од сургуулийн захирал

АГУУЛГА

- Сургуулийн зорилго
- Захирлын мэндчилгээ
- Сургуулийн уриа
- Сургуулийн бүтэц
- Сургалтын хөтөлбөр
 - Хэлний боловсрол
 - Математик
 - Хөгжүүлэх сургалтууд
 - ELSC / Англи хэлний сургалтын төв /
 - Гэрийн даалгавар
- Сургуулийн дүрэм
- Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа
 - Сургуулийн дүрэмт хувцас
 - Гутал солих
 - Эрүүл мэнд, аюулгүй байдал
 - Аюулгүй байдал
 - Хичээл тарсны дараа хяналт тавих
 - Монгол Од дахь гар утасны хэрэглээ
 - Хичээл таслах, чөлөө авах
 - Хичээлд ирэх, явах

- Өглөөний цай, үдийн хоол
- Спорт заал
- Сурагчдын хурал
- Сургуулийн автобусаар явах
- Сургуулийн үйл ажиллагааны тойм
- Алдагдсан, олдсон зүйлсийн тухай

Харилцаа холбоо

Эцэг эхтэй уулзах

Яаралтай тусламжийн үеийн холбоо барих
хаяг

Яаралтай тусламжийн үеийн утасны дугаар
Сургуультай холбоо барих утасны дугаар

Бидний уриа” Shine Like A Star!” – “Од мэт гялалз”

Бидний үнэ цэнэ "STARS" гэх үгийг бүрдүүлж буй эхний үсгүүдээс бүрддэг дараах үгнүүдээр төлөөлүүлдэг.

- Smart- Ухаалаг- оюунлаг байх буюу академик хичээлүүдийг маш сайн сурч эзэмшсэн байх
- Talented- Авьяаслаг- сурагчдын бүтээлч байдал, авьяас чадвараар илэрхийлэгдэнэ
- Active- Идэвхтэй- амьдралын идэвхтэй эрүүл хэв маягтай байх
- Role Model- Манлайлагч -хүндлэл хүлээцтэй, шаргуу зан чанарын үлгэр жишээ болдог байх
- Successful- Амжилттай- гайхалтай зүйлсийг бүтээж, мөрөөдлөө биелүүлэх, өмнөө тавьсан эцсийн зорилгодоо хүрэх тэмүүлэлтэй байх

1. Монгол Од сургалтын хөтөлбөр

Монгол улсын Боловсролын Цөм хөтөлбөр;

Америкийн Common core сургалтын хөтөлбөр;

Хөгжүүлэх сургалтын хөтөлбөр зэргийг сургалтандаа ашиглаж байна.

Монгол Од сургуулийн сургалтын хөтөлбөр нь сурагчдыг аливаа асуудлыг шийдвэрлэх чадварыг хөгжүүлж, дэлхийн иргэний хувьд бусадтай хамтран ажиллах, бусдын ижил төстэй, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх хандлагыг төлөвшүүлэхийг зорьдог.

Монгол Од сургууль Монгол, Англи хэл дээр сургалт явуулдаг. Сурагчид өдөр бүр англи хэлний сонсох, ярих, унших, бичих чадвараа дээшлүүлэх боломжтой. Манай сургууль Англи хэлийг эх хэлтэйгээ хослуулсан тэнцвэртэй хөтөлбөр санал болгодог. Сургуулийн Англи хэлний сургалтанд авиа зүй, унших, бичих, ярих чадварууд заадаг нь цаашид их сургуульд дэвшин суралцах, ажил мэргэжлээрээ амжилтанд хүрэхэд шаардлагатай хэлний чадваруудыг хөгжүүлэхэд тусалдаг.

Монгол од сургуулийн Математикийн хөтөлбөр нь Монгол улсын Боловсролын Цөм хөтөлбөр, Америкийн common core хөтөлбөртэй хавсран сургадаг ба уг хоёр хөтөлбөр математикийн үндсэн ойлголт, хэрэглээний талаар өргөн хүрээг хамардаг.

2. Англи хэлний сургалтын төв (ELSC) - Англи хэлний мэдлэгийг дэмжих төв

Монгол Од сургуульд шилжиж ирсэн болон Англи хэлний мэдлэгээ сайжруулахыг хүссэн сурагчид энэхүү сургалтанд оролцох боломжтой. Энэхүү төвд нэмэлт цагаар сурснаар тухайн суралцаж буй ангийнхаа суралцагчдын түвшинд хүргэхийг зорьж ажилладаг. Энэ хөтөлбөр нь үндсэн сургалтаас гадна тул нэмэлт төлбөртэй байна.

Монгол Од сургуулийн хөгжүүлэх хөтөлбөрийн сургалт нь сурагчдад амьдрах ур чадварыг нь хөгжүүлэх, цагийг үр бүтээлтэй өнгөрөөх зорилгоор хичээлээс гадуур хөгжүүлэх олон талт үйл ажиллагаагаар явагддаг. Монгол Од сургууль хүүхдийг зөвхөн академик талаас нь төдийгүй амьдрах чадварыг хөгжүүлснээр хүүхэд бүр насан туршдаа суралцагч байж, эргэн тойрныхоо хүмүүс, байгаа зүйлсээ үнэлдэг төлөвшсөн бие хүн болж өсөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хичээлээс гадуур олон төрлийн хөгжүүлэх сургалтыг сонгох боломж олгосноор хүүхэд сонирхол авьяас билэгээ нээн илрүүлэх боломж нэмэгдэнэ. Хөгжүүлэх сургалтын тайланг хичээлийн жилийн төгсгөлд хийнэ. Хөгжүүлэх сургалт нь Баасан гаригаас бусад өдөр 13.30-16.10 цагийн хооронд бүтэн жил явагдана. Таеквандо, сагсан бөмбөг, волейбол, йог, балет, шатар, аэробик зэрэг урлаг, спортын төрөл зүйл багтана.

3. Гэрийн даалгавар

Монгол Од сургууль нь гэрийн даалгаврыг бие даан суралцахь сурах дадал суулгах, сурлагын амжилтыг сайжруулах хэрэгсэл гэж үздэг. Гэрийн даалгавар нь сургууль ба гэр бүлийн

харилцааг бататгаж, эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ сурах үйл явцад оролцоход тустай. Гэрийн даалгаврыг сурагчдын мэдлэгийн түвшинд нь таарсан байх шаардлагатай.

МОНГОЛ ОД СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧДЫН ГЭРИЙН ДААЛГАВРЫН ЖУРАМ (HOMEWORK POLICY)

Нэг. Нийтлэг үндэслэл.

Монгол Од сургуулийн гэрийн даалгаврын зорилго нь суралцагчдын сургалтын амжилтыг сайжруулах, тэдний бие даан суралцах, сурах зөв дадал зуршил эзэмшүүлэх, сахилга баттай, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх, багш, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах, сургалтын үйл ажиллагаанд оролцуулахад чиглэгдэнэ.

Хоёр. Гэрийн даалгаврын бүтэц

- 2.1. Гэрийн даалгавар нь суралцагчийн нас, бие, хөгжлийн онцлогт тохирсон байна.
- 2.2. Бага ангийн сурагчдийн нэг хичээлээр өгөх гэрийн даалгаврын гүйцэтгэх хугацаа 10-20 минутаас ихгүй, дунд болон ахлах ангийн сурагчидад нэг хичээлээр өгөх гэрийн даалгаврын гүйцэтгэх хугацаа 20-30 минутаас ихгүй байхаар зохион байгуулна.
- 2.3. Сурагчдын үндсэн болон туслах хичээлийн агуулга, онцлог зэргийг тооцон нэг өдрийн бүх гэрийн даалгаврыг дараах хугацаанд багтаан хийж гүйцэтгэх анхаарна.

Анги	Өдөрт
1-р анги	20-40 минут
2,3,4-р анги	40-60 минут
5-р анги /төгсөлтийн шалгалт/	60-90 минут
6,7,8-р анги	90-120 минут
9-р анги /төгсөлтийн шалгалт/	120-150 минут
10-11-р анги	120-150 минут
12-р анги /төгсөлтийн шалгалт/	150-180 минут

Гурав. Багшийн эрх, үүрэг

- 3.1. Хичээлээр заасан мэдлэгийг бататгах агуулга бүхий гэрийн даалгавар өгөх
- 3.2. Өгөгдөж буй даалгаврыг хэрхэн гүйцэтгэх талаар заавар өгөх
- 3.3. Гэрийн даалгаврыг системд заавал оруулах
- 3.4. Гүйцэтгэсэн гэрийн даалгаврыг заавал шалгаж үр дүнг системд оруулах.

3.5. Суралцагч гэрийн даалгаварт хэрхэн хандаж байгаа талаар эцэг эхтэй зөвлөлдөх

3.6. Сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажилладаггүй эцэг эхтэй хамтран ажиллахаас түдгэлзэх санал гаргах /Хамтран ажиллах хүсэлгүй, хариуцлагагүй, харилцааны соёлгүй...гэх мэт/

3.7. Багш өөрийн зааж буй хичээлийн хөтөлбөрт тохирсон гэрийн даалгавар гүйцэтгэх дэвтэр, дасгал ажлын ном боловсруулж, хэвлүүлэн ашиглаж болно

Дөрөв. Суралцагчийн эрх, үүрэг

4.1. Өгөгдсөн гэрийн даалгаврын талаарх ойлгомжгүй зүйлээ багшаас асуух

4.2. Гэрийн даалгаврыг бие даан гүйцэтгэхийг эрмэлзэх /Анги хамт олон, найз нөхдийн хамтаар гэрийн даалгаврыг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн даалгаврын агуулгыг ойлгож мэдсэн байна/

4.4. Гэрийн даалгаврыг хугацаанд нь 100% гүйцэтгэж багшид шалгуулах

4. 5. Өдөр бүр 30 минутын тогтмол уншлага хийх

Тав. Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг

5.1. Гэрийн даалгавар гүйцэтгэх чимээгүй таатай орчин, нөхцлийг бүрдүүлж өгөх

5.2. Гэрийн даалгавар хийж дуустал нь телевиз, гар утаснаас хол байлгаж, гүйцэтгэлд

бүрэн хяналт тавина. /Сургууль дээр даалгавар хийсэн ч бүх даалгавраа бүрэн хийсэн эсэхийг нягтлах/

5.4. Сурагчийн дэвтэрт ямар нэг тэмдэглэл хийхээс зайлсхийх /өмнөөс нь даалгаврыг нь гүйцэтгэх гэх мэт/

5.5. Хүүхдийнхээ гэрийн даалгаварт хэрхэн хандаж байгаа, даалгаврын хэмжээ, үр дүнгийн талаар багштай холбогдож зөвлөлдөх

5.6. Гэрийн даалгавар хийх явцад хүүхдийг үнэлж, магтаж урамшуулах. Хүүхэд ядарсан бол түр завсарлуулж амраан дахин үргэлжлүүлж гэрийн даалгаврыг бүрэн хийж гүйцэтгүүлэх.

5.7. Суралцагчийг өдөр бүр тогтмол оройн 22:00 цагаас өмнө оронд нь оруулж унтуулсан байх ба 21:30 цагаас хойш гэрийн даалгавар хийлгэхгүй байхад анхаарах.

Зургаа. Бага ангийн сурагчдын гэрийн даалгавар

6.1. Гэрийн даалгаврын биелэлтийг багш хянаж, баримтжуулан бичилт хийнэ.

6.2. Анги удирдсан багш гэрийн даалгавар хийлгэхэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах.

6.3. Даваа-Пүрэв гарагуудад Монгол үндсэн болон туслах хичээлийн даалгавруудыг хамгийн боломжит бага хэмжээгээр өгөх ба Баасан-Ням гаригуудад даалгавар өгөхгүй.

/Зөвхөн Англи хэлний хичээл, олон улсын хөтөлбөрийн хичээлүүдээр гэрийн даалгавар өгч болно./

6.4. 1 дүгээр ангийн суралцагчид нь уншиж бичиж сурч байгаа тул тухайн хичээлийн жилийн эхний хагас жилд монгол хэлний хичээлд, 2-р хагас жилд англи хэлний хичээлд багш, эцэг эхчүүд түлхүү анхаарч хамтран ажиллана. Сурагчид нь амархан мартдаг тул бага хэмжээний, нэг зүйлийг олон дахин давтсан гэрийн даалгавар өгөх.

Долоо. Дунд болон ахлах ангийн суралцагчийн гэрийн даалгавар

7.1. Дунд, ахлах ангиудад байгалийн ухаан, нийгмийн ухаан, гадаад хэлний зэрэг олон төрлийн хичээл ордог тул гэрийн даалгавар, бие даах ажлууд нь үзсэн хичээлээ гэртээ үргэлжлүүлэн хийх, ойлгосноо бататгах, шинэ зүйл сурахад онцгой анхаарна.

7.2. Байгалийн шинжлэх ухааны хичээлийн гэрийн даалгаврын үнэлгээ нь улирлын дүнгийн 40 %, нийгмийн ухааны хичээлийн гэрийн даалгаврын үнэлгээ нь улирлын дүнгийн 20 %-тай тэнцэнэ.

Найм. Англи хэлний болон Олон улсын хөтөлбөрийн хичээлүүдийн гэрийн даалгавар

8.1. Англи хэлний сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор амралтын өдрүүдэд Англи хэлний хичээлийн даалгаврыг түлхүү хийнэ.

8.2. Англи хэлний сургалтанд ашиглаж буй Английн Express publishing хэвлэлийн газрын сурах бичгийн дасгал ажлын номноос /workbook/ гэрийн даалгаварт өгнө.

8.3. I-Science хичээлийн үндсэн сурах бичгийн дагуу гэрийн даалгавар өгөгдөх ба сурагчдыг биет үзүүлэн, макет хийлгэх даалгаврыг бие даалтаар өгч болно.

8.4. I-Math хичээлээр үндсэн сурах бичгийн хүрээнд бататгах бодлогыг бодож гэрийн даалгаврыг гүйцэтгэнэ.

Ес. Улирлын, өвлийн, зуны амралтын даалгавар

9.1. Урт хугацааны амралтаар /улирлын, өвлийн, зуны/ сурагцагчдын үзсэн хичээл, мэдлэгээ бататгах, мартажгүй байлгах зорилгоор амралтын даалгаврыг багш бүр бэлтгэн өгнө.

9.2. Амралтын даалгаврыг хичээл эхэлсэн эхний долоо хоногт багтаан хураан авч шалгаж үр дүнг системд оруулна.

Арав. Гэрийн даалгавраа биелүүлээгүй тохиолдолд

10.1. 1-3 тохиолдолд нөхцөл байдлыг харгалзан үзэж амаар сануулга өгч хийж дуусгах хугацаа өгнө.

10.2. 3-аас дээш удаагаа даалгавар биелүүлээгүй ирсэн тохиолдолд даалгавраа хийж дуустал хөгжүүлэх сургалт, дугуйлангаас түдгэлзүүлнэ.

10.3. Тухайн сурагч өмнөх анхааруулгуудыг үл хайхран гэрийн даалгавар хийгээгүй тохиолдолд багш, сурагч, эцэг эх, сургуулийн захиргаа оролцсон уулзалтанд оролцуулж цаашид хэрхэх талаар ярилцан амлалт бичүүлж авах.

10.4. Дээрх аргууд үр дүнгүйд тооцогдож хичээлээс хоцорсон тохиолдолд сургуулиас түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авна.

4. Аюулгүй байдал

Багш нар өөрсдийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж ажилласнаар суралцагчид нь:

- Хичээлийн цагаар ангидаа байх;
- Гарах зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд ангиас гарахгүй байх;
- Хичээлийн цагаар идэвхтэй суралцах;
- Сургууль руу нэвтэрч орох, гарах журмыг дагаж мөрдөх ;
- Аливаа аюултай зүйл биедээ авч явах, бусдыг гэмтээхийг хориглоно

5. Сурах

Багш нар бусадтай хамтран ажиллаж бусдад үлгэр дуурайл үзүүлснээр Суралцагчид нь

- Хичээлээс хоцрохгүй, хичээл таслахгүй байх
- Бусдад саад болохгүй, үр бүтээлтэй ажиллах;
- Ангийн дотоод журмыг баримтлах;
- Хамтран ажиллаж, бусадтай үр дүнгээ хуваалцана.

6. Харилцах

Сургууль дээр багш нар бусад хүмүүстэй эелдэг, найрсаг байдлаар харьцаж, үг яриа, үйл хөдлөлөөрөө хүндэтгэлтэй хандсанаар Суралцагчид нь

- Зөв харилцаа, эерэг хандлагатай;
- Бусдыг сонсож чаддаг;
- Шаардлагатай үед үйл хөдлөл, сэтгэл хөдлөлөө илэрхийлж чаддаг;
- Бусадтай эерэг харилцаатай;
- Сургуулийн үйл ажиллагааны талаар эцэг эхчүүдэд мэдээлэдэг байна.

7. Бусдыг хүндлэх, сургуулиа хүндлэх

Багштайгаа сурагчид болоод бусад хүмүүс хэрхэн харьцаасай гэж хүсэж байна түүн шигээ бусадтай харьцсанаар суралцагчид нь

- Багшийн заах, сурагчдын сурах эрхийг хүндэтгэж бусдад саад болохгүйгээр хичээлд оролцох;
- Сурагчийн дүрэмт хувцас, биеийн тамирын хувцас зэрэг хичээлийн бэлтгэлийг бүрэн хангаж ирэх;
- Бусдын болон сургуулийн өмчийг гамнах;
- Бусдын шаардлагыг хүлээн авч, биелүүлэх;

- Бусдыг доромжлох, дээрэлхэх, хүчирхийлэх, хараалын үг хэлэх, бүдүүлэг дохио зангаа үзүүлэх, ялгаварлан гадуурхах, бусдад дарамт шахалт үзүүлэхийг хориглох;
- Хүрээлэн буй орчныг хамгаалах;
- Хог хаягдлыг хогийн саванд хийх;
- Хувийн ариун цэвэр сахих;

8. Зөрчил, маргааныг шийдвэрлэх

Багш бусадтай холбоотой асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхийг хичээдэг. Ингэснээр Суралцагчид нь

- Асуудлыг тайван, ухаалаг, шударга байдлаар шийдвэрлэхийг хичээх;
- Асуудлаа тодорхой бөгөөд ойлгомжтой хэлэх;
- Багшийн тусламж шаардлагатай эсэхийг асуух;

9. Сургууль доторх хөдөлгөөн

Бид сургуулийн анги танхим, хичээлийн байранд явахдаа дараах дүрмийг баримтална.

- Чанга дуугаар ярихгүй байх;
- Баруун гарын дүрэм баримтлан явах;
- Гэмтэхээс болгоомжлох, үсэрч харайхыг хориглоно.

10. Сургуулийн дүрэмт хувцас

Бүх сурагчид хичээлдээ Монгол Од сургуулийн лого бүхий дүрэмт хувцасыг бүрэн өмсөнө. Сурагчид биеийн тамирын, бүжгийн хувцастай байна. Сурагчийн дүрэмт хувцас хэрхэн авах талаар сургуулийн 967-22222 утсаар дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

11. Сургуулийн дотор өмсөх гутал

Суралцагсад биеийн тамир, бүжгийн гутлаас гадна өдөр тутам өмсөх сургуулийн гутлаа үлдээж сургууль руу нэвтрэх үедээ сольж өмсөж байна.

12. Хичээлийн дараа

Сурагчид хичээл тарахад эцэг эх, асран хамгаалагч ирж авна. Хэрвээ таны хүүхэд хичээлийн дараа гэрлүүгээ ганцаараа явдаг эсвэл эцэг эхээс өөр хүн ирж авах бол эцэг эх зөвшөөрлийн хуудас бөглөн баталгаажуулж ангийн багшид заавал өгсөн байна.

13. Монгол Од сургуулийн орчинд гар утасны хэрэглээ

Хүүхдүүд хичээлийн цагаар ухаалаг гар утас, цахим тоглоомын хэрэгсэл ашиглахыг хориглоно.

Хичээлийн дараа эцэг эхтэйгээ холбоо барих зайлшгүй шаардлагаар энгийн утас авчирсан тохиолдолд гар утсаа ангийн багшид түр хадгалуулж хичээл тарсны дараа буцаан авна.

Гар утсаа хулгайд алдсан, гэмтээсэн тохиолдолд сургууль болон багш хариуцлага хүлээхгүй.

Хичээлийн цагаар ар гэртэйгээ холбоо барих шаардлагатай бол сургуулийн утас ашиглаж болно.

Өглөөний цай, өдрийн хоол, хөгжүүлэх сургалтын цагаар гар утас ашиглахыг хориглоно.

14. Хичээл таслах, чөлөө авах

Хэрэв таны хүүхэд ямар нэгэн шалтгаанаар сургуульдаа ирэхгүй бол ангийн багшид мэдэгдэнэ.

Аливаа өвчний ялангуяа халдварт өвчний шинж тэмдэг хүүхдэд тань илэрвэл сургуульд яаралтай мэдэгдэх, хичээлд ирүүлэхгүй байх нь аливаа эрсдэл, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд нэн чухал ач холбогдолтой. Хүүхэд тань сургууль дээр байхдаа өвдсөн тохиолдолд тантай холбоо барина. Өвдөхөөс бусад шалтгаанаар сургуулиас чөлөө авахгүй байвал зохистой.

15. Сургуульд ирэх цаг

Сурагчид 8.00-08.20 хооронд ирнэ.

Сургуулийн автобус 08.20 ирнэ.

Хичээл 8:30 цагт эхэлнэ. 1 цагийн хичээл 40 минут үргэлжилнэ.

Хөгжүүлэх сургалт хуваарийн дагуу 13.30-14.00-цагт эхэлнэ.

16. Тарах цаг (Даваа-Пүрэв)

Сургалтын үйл ажиллагаа дуусангуут эцэг эхчүүд хүүхдүүдээ авч болно.

16.30-аас сургуулийн автобус хөдөлнө.

18.00 цагт сургуулийн үйл ажиллагаа бүрэн дуусна.

(Баасан гаригт)

Баасан гаригт жижүүр багш ажиллана. Багш нар дараагийн долоо хоногийн хичээлдээ бэлдэх, сургалт семинар, төлөвлөгөөт хуралд суух шаардлагатай тул хичээл 12.10-14:00 цагт тардаг. Иймд та хүүхдээ хичээлийн дараа цагтаа авах хэрэгтэй, боломжгүй тохиолдолд сургууль 18.00 цаг хүртэл төлбөртэй өдөр өнжүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

17. Сургуулийн хоол

Хоолны танхимд сурагчдыг хуваарьт ширээнд суулган, ангийн багшийн хяналтанд хоолыг түгээнэ.

Монгол Од сургуулийн цайны газарт мэргэжлийн тогооч, ажилчид амт чанар сайтай, хүнсний стандартад нийцсэн хоолоор үйлчилдэг. Шаардлагатай тохиолдолд сурагчид гэрээсээ өдрийн хоол авчирч идэж болно. Хүүхдүүд сургууль дээр чихэр, амттан, хийжүүлсэн ундаа авчрахыг зөвшөөрөхгүй. Хүүхдүүд өөрсдийнхөө нэр, таних тэмдэгтэй, усны сав авчирч ус хангалттай сайн уухыг зөвлөдөг.

18. Мэдээлэл технологийн өрөө

Манай Мэдээлэл технологийн өрөө нь зориулалтын ширээ, сандал, чихэвчтэй 15 компьютер ашиглан IXL хөтөлбөр дээр суурилсан Шинжлэх ухааны хичээл ороход ашигладаг. Хичээлийн бус цагаар багшийн зөвшөөрлөөр ашиглана.

19. Спорт заал

Спортын заал нь биеийн тамирын хичээл заахад ашиглагддаг. Багшийн хараа хяналтгүйгээр спортын зааланд тоглохыг хориглоно. Чөлөө цагаараа сдортор хичээллэх бол багшаас зөвшөөрөл авна.

20. Сургуулиас гадуурхи ажил

Сургуулиас гадна суралцах боломжийг бид үргэлж дэмжиж ирсэн.

Жилд нэг удаа ангиараа аялалд явдаг.

Өвлийн амралтаар хүүхдийн Найрамдал, Янзага зусланд ангиараа амардаг

Ангийн багш судалж буй хичээлийн сэдэвтэй холбоотойгоор сургуулиас гадуур музей, театр үзэх, дурсгалт газраар явах зэргээр зохион байгуулдаг. Монгол Од сургууль аль нэг шашинтай холбоотой аялалд сурагчдаа оролцуулахыг зөвшөөрөхүй.

21. Даваа гарагийн өглөөний уулзалт

Даваа гараг бүрийн 08.15 цагт тухайн 7 хоногийн нээлтийн үйл ажиллагаа сургуулийн биеийн тамирын зааланд болно. Нийт багш, сурагчид оролцож сургууль дээр зохиогдох арга хэмжээний талаар мэдээлэл авч, амжилт гаргасан сурагчдыг шагнаж урамшуулахын зэрэгцээ , нийт суралцагчид дасгал хөдөлгөөн, бүжиг хийж, Америк Монголын төрийн дуулал дуулдаг.

22. Сургуулийн автобус

Таны хүүхэд сургуулийн автобусаар үйлчлүүлэх тохиолдолд эцэг эх хүсэлт гаргаж, төлбөрөө төлсөнөөр гэрээ байгуулна. Сургуулиас гаргасан маршрутын дагуу гэрийнхээ ойролцоо автобусны зогсоолоос автобусандаа сууна. Эцэг эхчүүд хүүхдүүддээ автобусанд суухдаа хамгаалах бүсээ зүүж, гар, хөлөө савчилгүй, нам дуугаар ярилцаж байхыг сануулж хэлнэ үү. Жолооч Р.Баярбаттай 96017864 утсаар холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Хичээлийн жилд болох үйл ажиллагааны хуваарийг Mongol Од сургуулийн цахим хуудас болон сургуулийн угтах танхимд байрлуулдаг.

23. Хаясан гэсэн эд зүйлс

Эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээлийн болон бусад эд хэрэглэгдэхүүн дээр нэр, ангийг бичиж өгч явуулбал зүйтэй. Нэр, таних тэмдэгтэй эд зүйлсийг сурагчдад буцааж өгнө. Нэр таних тэмдэггүй эд зүйлс (намц, цүнх, хүрэм гэх мэт) -ийг Монгол Од сургуулийн үүдний ойролцоо байх хаясан гэсэн зүйлийн хайрцагт хадгална. Өндөр үнэтэй эд зүйлс сургууль дээр зүйл авчрахыг хориглох

бөгөөд бөгөөд алдаж гээсэн тохиолдолд Монгол Од сургуулийн багш, ажилтан албан хаагч, бусад сурагчид хариуцлага хүлээхгүй болно.

24. Харилцаа холбоо

Эцэг эхчүүдтэй нээлттэй харилцаатай байх нь бидний нэн тэргүүний зорилтуудын нэг юм. Асуулт, санал гомдол байвал бидэнтэй холбогдож болно. Хэрэв та ангийн багштай уулзах шаардлагатай бол тэдэнтэй урьдчилан холбоо барьж, харилцан тохирч цаг авч уулзах шаардлагатай.

25. Эцэг эхийн хурал

Хүүхдийнхээ талаар эцэг эхчүүдтэй уулзах албан ёсны уулзалтыг улирал бүр зохион байгуулдаг. Энэ хичээлийн жилд төлөвлөгдсөн хугацаа нь:

1-р улирлын эцэг эхийн хурал -Баасан гариг, 2 дахь 7 хоног, 9 сар

2-р улирлын эцэг эхийн хурал -Баасан гариг, 2 дахь 7 хоног, 12 сар

3-р улирлын эцэг эхийн хурал-Баасан гариг, 2 дахь 7 хоног, 4 сар

Та эцэг эхийн хурал болох сар өдөр, оролцох цагийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг ангийн багшаас хүлээн авах болно.

26. Яаралтай холбоо барих

Сургууль эрт тарах онцгой байдлын үед таньтай утсаар холбоо барих болно. Та утасны дугаараа шинэчлэвэл ангийн багшид дор бүр нь тэмдэглүүлж байгаарай.

Таньтай холбогдох боломжгүй үед холбоо барьж болох гэр бүлийн гишүүн, хөрш, найз, хамт ажиллагсдынхаа нэр, утасны дугаарыг өгөх шаардлагатай.

СУРГУУЛИЙН ХОЛБОО БАРИХ

И-мэйл: info@mongol-od.edu.mn

Веб сайт: www.mongol-od.edu.mn

Утас: + 976-9673-3333, 976-9672-2222

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот. Баянгол дүүрэг, 3-р хороо